



*Аймгийн ИТХ-ын захиалгын дагуу Хэнтий аймгийн
Аудитын газрын 2016 онд хийсэн НИЙЦЛИЙН АУДИТ*



**Мэргэжлийн сургалтыг дэмжих
чиглэлээр олгосон хандив тусламж,
төсөл хөтөлбөрийн хөрөнгийг
зориулалтын дагуу зарцуулж байгаа
боловч зарим төслийн хэрэгжилт үр
дүнгүй байна.**

Аудитын нэр: Мэргэжлийн
сургалтыг дэмжих
чиглэлээр олгосон хандив,
тусламж, төсөл
хөтөлбөрийн хөрөнгийн
зарцуулалт

Аудитын код: ХЭАГ/ 2016 /02- НА-
ХЭ

Чингис хот
2016.07.25

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

[illegible]

Тайлан бэлтгэсэн ҮАГ-ын харъяа Хэнтий аймгийн Аудитын газар Хэнтий аймаг Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Энхтүвшин Аудитын менежер: Б.Наранцэцэг Ахлах аудитор: Н.Туяа 2016 оны 06 дугаар сар Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймгийн Аудитын газрын 7056-2147, 98332147 тоот утас, khentii@audit.gov.mn, 70562112 факсаар харилцана уу. Хаяг: Хэнтий аймаг Чингис хот АЗДТГ-ын байр. 325 тоот өрөө	АГУУЛГА	
	Ерөнхий зүйл	
	Аудитын нэр,код	3
	Аудит хийсэн үндэслэл, хугацаа	3
	Аудитын зорилт , хамарсан хүрээ	3
	Үндсэн мэдээлэл	3-4
	Нэг. Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хөрөнгө хуулийн дагуу олгогдсон боловч аймагын МСҮТ нь зарим хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй байна.	5-7
	1.1 Мэргэжлийн боловсрол олгох чиглэлээр олгосон хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн олгосон байна.	5-7
	1.2 Аймагын МСҮТ нь хандив, тусламж, төсөл хөтөлбөрөөс ирсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна.	7-8
	1.3 Олгогдсон хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байна.	8-9
	Хоёр. Мэргэжлийн боловсрол олгох чиглэлээр ХЭДС-аас олгосон төсөл, хөтөлбөрийн 36.3 сая төгрөгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч 8.4 сая төгрөгийн төслийн хэрэгжилт үр дүнгүй байна.	10
	2.1. Мэргэжлийн боловсрол олгох чиглэлээр ХЭДС-аас олгосон төсөл, хөтөлбөрийн 36.3 сая төгрөгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч 8.4 сая төгрөгийн төслийн хэрэгжилт үр дүнгүй байна.	10-12
	2.2. Зарим бүлэгт олгосон төслийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.	12
	Гурав. Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хандив, тусламж, төсөл хөтөлбөрөөр олгосон хөрөнгөд хяналт шалгалт хийгдээгүй байна.	13
	Тав. Дүгнэлт	13
	Зургаа. Аудитын зөвлөмж	13
	Долоо. Холбогдох байгуулагын санал	14-15
	Найм. Хавсралтууд.....	16
	Олгосон хөрөнгийн жагсаалт	

Ерөнхий зүйл

Аудитын нэр: Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хандив, тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалт

Аудитын код: ХЭАГ/ 2016 /02- НА-ХЭ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг “Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Нийслэлийн болон аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх”-ийн хүрээнд Хэнтий аймгийн Аудитын газар гүйцэтгэв.

Аудитын зорилт

2015 онд Хэнтий аймгийн МСҮТ, Бор-Өндөр дахь МСҮТ, ХЭДС-д мэргэжлийн сургалтыг дэмжих зорилгоор олгосон хандив тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалтыг шалгаж, дүгнэлт гарган, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хөрөнгийг бүртгэлд тусгасан уу?
- Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан уу?
- Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хөрөнгийн ашиглалт үр дүнтэй байна уу?

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг 2015 онд аймгийн МСҮТ, Бор-Өндөр дахь МСҮТ, ХЭДС-д мэргэжлийн сургалтыг дэмжих зорилгоор олгогдсон хөрөнгийн зарцуулалтын тайлан, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл, холбогдох мэдээ, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл

2015 онд Хэнтий аймагт мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр төсөл хөтөлбөр, хандив тусламжаас **нийт 394.5 сая төгрөгийн** хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

1. Мэргэжлийн боловсролыг дэмжих сангаас: Хэнтий аймаг дахь МСҮТ-д 141.3 сая төгрөг, Бор-Өндөр дахь МСҮТ-д 59.0 сая төгрөг тус тус ирж, 200.3 сая төгрөгийн оюутны тэтгэлэгийг оюутнуудад олгожээ.

2. Хөдөлмөрийн яамны хөрөнгө оруулалтаар: Хэнтий аймаг дахь МСҮТ-д 87.8 сая төгрөгийн, Бор-Өндөр дахь МСҮТ-д 2.9 сая төгрөгийн гагнуурын тоног төхөөрөмжүүдийг тус тус олгожээ.

3. Хөдөлмөрийн яамнаас: 2015 онд мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд:

1. “Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-өөр 36.2 сая төгрөгийн,
 2. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрөөр аж ахуй эрхлэлтийн сургалтанд 2.4 сая төгрөгийн,
 3. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөрөөр үйлдвэрлэл дээрх сургалтын 18.7 сая төгрөгийн ,
 4. Мэргэжлийн болон давтан явуулын сургалт 6.5 сая төгрөгийн,
 5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөр аж ахуй эрхлэлтийн болон хөдөлмөр эрхлэлтийн сургалт явуулсан 6.0 сая төгрөгийн,
- нийт 69.8 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

4. ДЗМОУБ-ын Хэнтий ОНХХ-өөс: Хэнтий аймаг дахь МСҮТ-д 17,0 сая төгрөгийн 13 ш хүлэмжийг олгосон байна.

5. ДЗМОУБ-ын Бор-Өндөр 2 ОНХХ-өөс: Хөдөлмөр хэлтсийн сургалтад зориулж сургалтын өрөөний ширээ, сандал, компьютер, прожектор зэрэг 6 нэр төрлийн 9.3 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг бэлэглэлийн гэрээгээр олгосон байна.

6. Барилга хот байгуулалтын яамнаас аймгийн МСҮТ-д “Сумын төвийн шинэчлэл” төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сумын төвийн Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллах хүнийг сургаж, мэргэжлийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах сургалтын зардал 7.4 сая төгрөгийн санхүүжилт ирсэн байна.

Аудитаар хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, олгосон төслийн хэрэгжилт хангалтгүй зэрэг нийт 25.4 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс холбогдох ТЕЗ, байгууллага, албан тушаалтанд зөрчлийг арилгах 8.4 сая төгрөгийн 1 хугацаатай албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад дараахь хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
- Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 10 дугаар сарын 18-ны 88 тоот тогтоол
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудит хийсэн хугацаа:

Аудитыг 2016 оны 05 дугаар сарын 23-наас 07 дугаар сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Энхтүвшин удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Наранцэцэг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Туяа гүйцэтгэв.

- Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хөрөнгө хуулийн дагуу олгогдсон боловч аймгийн МСҮТ нь зарим хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй байна.

1.1. Мэргэжлийн боловсрол олгох чиглэлээр олгосон хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн олгосон байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасны дагуу Мэргэжлийн боловсролыг дэмжих сангаас МСҮТ-үүдэд оюутны тэтгэлгийн санхүүжилтийг олгосон байна.

Хэнтий аймгийн МСҮТ-д Монгол улсын Барилга хот байгуулалтын яамны 2015,02,17-ны 3/510 тоот бичиг “Монгол улсын ЗГ-аас 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Сумын төвийн шинэчлэл” төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сумын төвийн Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллах хүнийг сургаж, мэргэжлийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах сургалтын зардал 7.4 сая төгрөгийн санхүүжилт ирснээс багш нарын цалинд 1,1 сая төгрөг, томилолт 1.5 сая төгрөг, сургалтын зардал 1.9 сая төгрөг, нийт 4.5 сая төгрөгийг зарцуулж, 2.9 сая төгрөгийг зарцуулаагүй төсөвт төвлөрүүлсэн байна.

Мөн Хэнтий аймаг дахь МСҮТ-д Хөдөлмөрийн яамны хөрөнгө оруулалтаар Гангар Орд ХХК-иас 18 төрлийн 87.8 сая төгрөгийн гагнуурын тоног төхөөрөмжийг ирүүлж, ДЗМОУБ-ын Хэнтий ОНХХ-өөс 17,0 сая төгрөгийн 13 ш хүлэмжийг тусламжаар ирүүлсэн байна.





Хэнтий МСҮТ-д Хөдөлмөрийн яамнаас олгосон гагнуурын тоног төхөөрөмжүүд



ДЗМОУБ-ын Хэнтий ОНХХ-өөс олгосон 13 ш хүлэмж

Хөдөлмөр хэлтсийн сургалтад зориулж ДЗМОУБ-ын Бор-Өндөр 2 ОНХХ-өөс сургалтын өрөөний ширээ, сандал, компьютер, прожектор зэрэг 6 нэр төрлийн 9.3 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг бэлэглэлийн гэрээгээр олгосон байна.



Хөдөлмөрийн хэлтсийн сургалтын өрөөнд олгосон ширээ, сандал, ноотвүүк, прокетор, өсгөгч, ус буцалгагч

2015 онд мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр ХЭДС-аас дараах хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс ХЭДС-ийн тухай хуулийн дагуу санхүүжүүлсэн байна. Үүнд:

1. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрөөр аж ахуй эрхлэлтийн сургалт,
2. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөрөөр үйлдвэрлэл дээрх сургалт, мэргэжлийн болон давтан явуулын сургалт,
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөр аж ахуй эрхлэлтийн болон хөдөлмөр эрхлэлтийн сургалт явуулах,
4. Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр тоног төхөөрөмжөөр хангах

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 7 дугаар тогтоолоор батлагдсан “Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 4.2.5-д “.. төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бага оврын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг бэлтгэх ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, төгсөлтийн дараа шууд төслөө хэрэгжүүлэх боломжоор хангана.” гэж заасан боловч Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төвөөс “Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн” –ийн санхүүжилт олгох арга хэмжээг хэрэгжүүлэхдээ төслүүдийн төсөвт өртгийн хэмжээнд хөрөнгийг тухайн бүлэгт шилжүүлж, зориулалтын дагуу зарцуулахад нь бүлгүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах гэсэн чиглэлийг өгсний дагуу ХЭДС-ийн батлагдсан хуваарийн дагуу Хөдөлмөрийн хэлтэс нь шалгарсан 5 бүлгийн ахлагч нарын дансанд тоног төхөөрөмж авах 36.3 сая төгрөгийг 2015 оны 11 дүгээр сарын 25 –нд бүлэг бүртэй гэрээ байгуулан, багийн ахлагч нарын дансанд шууд шилжүүлсэн байна.

1.2. МСҮТ нь хандив, тусламж, төсөл хөтөлбөрөөс ирсэн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасны дагуу Мэргэжлийн боловсролыг дэмжих сангаас Хэнтий аймаг дахь МСҮТ-д 141.3 сая төгрөгийг, Бор-Өндөр дахь МСҮТ-д 59.0 сая төгрөгийг оюутны тэтгэлэгт тус тус олгосныг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд бүртгэж тайлагнасан байна.

Мөн Хэнтий аймаг дахь МСҮТ-д Хөдөлмөрийн яамны хөрөнгө оруулалтаар олгосон Гангар Орд ХХК-иас 87.8 сая төгрөгийн 18 төрлийн гагнуурын тоног төхөөрөмж, Бор-Өндөр дахь МСҮТ-д 2.9 сая төгрөгийн 2 ш гагнуурын тоног төхөөрөмж, 10.0 сая төгрөгийн E-TVET мэдээллийн программийг үндсэн хөрөнгийн дансанд тус тус орлого авч бүртгэсэн байна.

Харин аймгийн МСҮТ нь ДЗМОУБ-ын Хэнтий ОНХХ-өөс олгосон 17,0 сая төгрөгийн 13 хүлэмжийг данс бүртгэлд бүртгээгүй байна. Энэ нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 10 дугаар сарын 18-ны 88 тоот тогтоолоор баталсан **“Эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 3.3 “Гадаадын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн төсөл, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг тухайн иргэн, хуулийн этгээдийн албан ёсны зөвшөөрлийг авсны үндсэн дээр үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгаж байх асуудлыг хөрөнгө хүлээн авч буй хуулийн этгээд өөрөө хариуцна.”** гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Хөдөлмөрийн хэлтэст ДЗМОУБ-ын Бор-Өндөр 2 ОНХХ-өөс сургалтын өрөөний ширээ, сандал, компьютер, прожектор зэрэг 6 нэр төрлийн 9.3 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг бэлэглэлийн гэрээгээр олгосныг үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмжийн дансанд 8.8 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж болох 0,8 сая төгрөгийн 1 ш прожектор, 1.7 сая төгрөгийн зөөврийн компьютер 1ш, 4.6 сая төгрөгийн 20 ш ширээ, 1.6 сая төгрөгийн 40 ш сандал, аж ахуйн материалын дансанд 0.5 сая төгрөгийн 1 ш зөөврийн өсгөгч, 0.1 сая төгрөгийн 1 ш ус буцалгагчийг тус тус орлогодож, бүртгэсэн байна.

2015 онд мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр ХЭДС-аас:

1. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрөөр аж ахуй эрхлэлтийн сургалтын 2.4 сая төгрөгийг,

2. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөрөөр үйлдвэрлэл дээрх сургалтын 18.7 сая төгрөг , мэргэжлийн болон давтан явуулын сургалт 6.5 сая төгрөг,

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөр аж ахуй эрхлэлтийн болон хөдөлмөр эрхлэлтийн сургалт явуулсан 6.0 сая төгрөг,

4. Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр тоног төхөөрөмжөөр хангасан 36.3 сая төгрөгийг хөтөлбөрийн зардалд бүртгэж тайлагнасан байна.

Эдгээр тоног төхөөрөмжүүдийг “Батхэлхээ”, “Урлан арвижих”, “Гэрэлт ирээдүй” бүлгүүдэд Хэнтий аймгийн “УЗАТ” ХХК, “Хөгжил дэвшилд хамтдаа”, “Тэнхлэг” бүлгүүдэд Хэнтий аймгийн “Поверлайн Товер” ХХК бэлтгэн нийлүүлсэн байна.

1.3. Олгогдсон хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хяналтыг сайжруулж ажиллах шаардлагатай байна.

Мэргэжлийн боловсролыг дэмжих сангаас Хэнтий аймаг дахь МСҮТ-д 141.3 сая төгрөгийг, Бор-Өндөр дахь МСҮТ-д 59.0 сая төгрөгийг оюутны тэтгэлэгийн зарцуулалтыг Засгийн газрын тусгай сангийн аудитаар шалгах тул хугацаанаас шалтгаалан энэхүү аудитаар нарийвчлан шалгаагүй болно.

Төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар олгогдсон хөрөнгийн хадгалалт хамгаалалт, хяналтыг хангалттай хэрэгжүүлж буй эсэхийг тулган баталгаажуулахад:

1. Аймгийн МСҮТ-д хөрөнгө оруулалтаар олгосон гагнуурын тоног төхөөрөмжүүд, ХЭДХ-т ДЗМОУБ-аас олгосон сургалтын өрөөний ширээ сандал тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусган кодолж, картаар эзэмшүүлсэн байна.
2. Харин ХЭДС-аас хэрэгжүүлсэн Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр олгосон тоног төхөөрөмжийг үзэхэд С.Дуламсүрэн ахлагчтай “Урлан арвижих” бүлэгт 7.7 сая төгрөгийн оёдлын , Л.Сэр-Од ахлагчтай “Гэрэлт ирээдүй” бүлэгт 7.9 сая төгрөгийн талх нарийн боовны цехийн тоног төхөөрөмжүүд ажлын байранд байна.
3. Б.Баяраа ахлагчтай “Бат хэлхээ” бүлэгт 3.2 сая төгрөгийн гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засварын тоног төхөөрөмжүүдийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.



”Батхэлхээ” бүлгийн авсан цахилгааны тоног төхөөрөмжүүд.

4. Б.Лхамлхүндэв ахлагчтай “Тэнхлэг” бүлэгт 9.1 сая төгрөгийн авто засварын тоног төхөөрөмж багаж хэрэгслийг үзэхэд ихэнх тоног төхөөрөмжийг авч үйл ажиллагаандаа ашиглаж байгаа боловч 1.2 сая төгрөгийн зарим тоног төхөөрөмж ажлын байранд байхгүй байна.
5. Т.Ариун-Эрдэнэ ахлагчтай “Хөгжил дэвшилд хамтдаа” бүлэгт 8.4 сая төгрөгийн хэвлэлийн эх бэлтгэлийн тоног төхөөрөмжөөр хангасан гэх боловч аудитад тоног төхөөрөмжийг аудитад хамруулаагүй болно.



6. Аудитын эцэст тус бүлэг үйл ажиллагаагаа Улаанбаатар хотод явуулж байгаа гэсэн хариу Хөдөлмөрийн хэлтсээс ирүүлсний дагуу газар дээр нь очиж шалгахад нуруу наагч, өнгөт принтер, лазер принтер, зургийн аппарат, аяган дээр зураг буулгагч гэсэн 5 ширхэг 2.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг үзүүлж, бусад

хавтас наагч, пластик карт зүсэгч, 2 ширхэг компьютер, хулдаасан хэвлэгч машин зэрэг 5 ширхэг 5.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж байхгүй байв.

Иймээс олгосон хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах хэрэгтэй байна.

Хоёрдугаар бүлэг

- Мэргэжлийн боловсрол олгох чиглэлээр ХЭДС-аас олгосон төсөл, хөтөлбөрийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч 8.4 сая төгрөгийн төслийн хэрэгжилт үр дүнгүй байна.

2.1. Мэргэжлийн боловсрол олгох чиглэлээр ХЭДС-аас олгосон 36.3 сая төгрөгийн төсөл, хөтөлбөрийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч 8.4 сая төгрөгийн төслийн хэрэгжилт үр дүнгүй байна.

Хэнтий аймгийн МСҮТ-д Монгол улсын Барилга хот байгуулалтын яамны 2015,02,17-ны 3/510 тоот бичиг “Монгол улсын ЗГ-аас 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Сумын төвийн шинэчлэл” төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сумын төвийн Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллах хүнийг сургаж, мэргэжлийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах сургалтын зардал 7.4 сая төгрөгийн санхүүжилт ирснээс төслийг бүрэн хэрэгжүүлж, 16 хүнийг сургасан байна.

2015 онд мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр ХЭДС-аас:

1. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрөөр эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 105 иргэнд “Хэрлэн бизнес хөгжил нийгэмлэг” ТББ-тай хамтран аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулж 2.4 сая төгрөгийг зарцуулжээ.

2. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөрөөр Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэртэй хамтран үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулж ажил олоход хүндрэлтэй 25 иргэнтэй гэрээ байгуулан машин механизм, төхөөрөмжийн засварчин мэргэжлээр дадлагажин суралцаж 18 иргэнийг ажлын байранд зуучлан оруулж 18.7 сая төгрөгийг, мэргэжлийн болон давтан явуулын сургалтаар Зөгийн аж ахуй эрхлэх сургалтыг Монголын зөгийчдийн холбоотой хамтран

Батширээт суманд 15 иргэнд, Улаанбаатар хотын “Жигүүрт авзага хайрхан” ХХК-ны дэргэдэх “Бүтээлч урлан” сургалтын байгууллагатай хамтран ажил олоход 11 иргэнийг гар урлал, бэлэг дурсгалын зүйл хийх сургалтыг 11 хүнд, Сүү цагаан идээ бэлтгэх сургалтанд “Футур” сургалтын байгууллагаар Өмнөдэлгэр, Батширээт, Батноров, Баян-Овоо, Баянхутаг, Мөрөн, Хэрлэн сумын 17 иргэнийг хамруулан, 3 удаа зохион байгуулж 6.5 сая төгрөгийг зарцуулжээ.

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрөөр буцалтгүй олгох санхүүгийн дэмжлэгт хамрагдан ажлын байртай болж байгаа 60 иргэнийг “Хэрлэн бизнес хөгжил нийгэмлэг” ТББ-тай хамтран аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулж бизнесийн анхан шатны мэдэгдэхүүн төсөл бичих аргачлал, мэдлэгийг олгож, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд “Уран гар” ТББ-тай хамтран болон хөдөлмөр эрхлэлтийн сургалт явуулж 6.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

4. Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгссөн 3-аас доошгүй иргэнтэй 5 хүртэлх гишүүнтэй бүлгийн мэргэжлийн чиглэлээр аж ахуй эрхлэх хүсэлтэй төгсөгчдийн бүлгээс 11 бизнес эрхлэх төслийг хүлээн авч сонгон шалгаруулж, 5 төслийг хэрэгжүүлж байна.

Т.Ариун-Эрдэнэ ахлагчтай “Хөгжил дэвшилд хамтдаа” бүлэгт 8.4 сая төгрөгийн хэвлэлийн эх бэлтгэлийн, Б.Лхамлхүндэв ахлагчтай “Тэнхлэг” бүлэгт 9.1 сая төгрөгийн авто засварын, С.Дуламсүрэн ахлагчтай “Урлан арвижих” бүлэгт 7.7 сая төгрөгийн, Л.Сэр-Од ахлагчтай “Гэрэлт ирээдүй” бүлэгт 7.9 сая төгрөгийн талх нарийн боовны цехийн, Б.Баяраа ахлагчтай “Бат хэлхээ” бүлэгт 3.2 сая төгрөгийн гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засварын тоног төхөөрөмжөөр тус тус ханган, 36.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Эдгээр шалгарсан 5 төслөөс 2016 оны 1 сараас эхлэн дараах 4 төсөл үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнд:

- Б.Лхамлхүндэв ахлагчтай “Тэнхлэг” бүлэг 9.1 сая төгрөгийн авто засварын тоног төхөөрөмж авч дугуй засварын газар,
- С.Дуламсүрэн ахлагчтай “Урлан арвижих” бүлэг 7.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр оёдлын газар,
- Л.Сэр-Од ахлагчтай “Гэрэлт ирээдүй” бүлэг 7.9 сая төгрөгийн талх нарийн боовны цехийн тоног төхөөрөмжөөр цайны газар,
- Б.Баяраа ахлагчтай “Бат хэлхээ” бүлэгт 3.2 сая төгрөгийн гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засварын тоног төхөөрөмжөөр цахилгааны засвар, үйлчилгээг тус тус одоогоор эрхэлж байна.

Эдгээр бүлгүүдэд үйл ажиллагаагаа эрхлэхэд зах зээлд шинээр байр сууриа эзлэх, санхүүгийн эх үүсвэр, үйл ажиллагаа явуулах байрны асуудал зэрэг хүндрэлтэй асуудлууд тулгарсан байна.



Бүлгийн оёж урласан бүтээлүүд



“Урлан арвижих” бүлгийнхэн
нь

“Бат хэлхээ” бүлгийнхэн ажил гүйцэтгэж байгаа



“Бат хэлхээ” бүлгийнхэн

Хөтөлбөр хэрэгжүүлэгч “Тэнхлэг”, “Урлан арвижих”, “Гэрэлт ирээдүй”, “Бат хэлхээ” бүлгийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтэд уг төсөл ихээхэн дэмжлэг болж байна.

Харин Т.Ариун-Эрдэнэ ахлагчтай “Хөгжил дэвшилд хамтдаа” бүлэгт 8.4 сая төгрөгийн хэвлэлийн эх бэлтгэлийн тоног төхөөрөмжийн санхүүжилт авсан боловч одоогоор үйл ажиллагаа явуулаагүй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд гэрээний дагуу хяналт тавих үүргээ ХЭДС-ийн ажилтнууд биелүүлж ажилласан гэх боловч хяналт тавьсан талаар тайлан, мэдээ байхгүй, Т.Ариун-Эрдэнэ ахлагчтай “Хөгжил дэвшилд хамтдаа” хэвлэлийн эх бэлтгэлийн бүлгийн байршил тодорхойгүй, уг бүлэг нь гэрээний заалтаа мөрдөж ажиллаагүй байна.

2.2 Зарим бүлэгт төслөөр олгосон хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.

Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгогдсон хандив, тусламж, төсөл хөтөлбөрөөр олгогдсон хөрөнгийн ашиглалтыг үзэхэд :

1. Аймгийн МСҮТ нь 2015 онд олгогдсон гагнуурын тоног төхөөрөмжийг сургалт, дадлаганд ашиглан, 2015 онд 13 суралцагчийг гагнуурчны мэргэжилтэй болгожээ.
2. Мөн дэлхийн зөн олон улсын байгууллагаас олгосон 17.0 сая төгрөгийн 13 хүлэмжийг фермерийн ангийн сургалтанд нарийн ногоо тарихад ашиглаж байна.



3. Хөдөлмөр хэлтэст ДЗМОУБ-ын Бор-Өндөр 2 ОНХХ-өөс сургалтын өрөөний ширээ, сандал, компьютер, прожектор зэрэг 6 нэр төрлийн 9.3 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг бэлэглэлийн гэрээгээр олгосныг үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмжийн дансанд 8.8 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж

болох 0,8 сая төгрөгийн 1 ш прожектор, 1.7 сая төгрөгийн зөөврийн компьютер 1ш, 4.6 сая төгрөгийн 20 ш ширээ, 1.6 сая төгрөгийн 40 ш сандал, аж ахуйн материалын дансанд 0.5 сая төгрөгийн 1 ш зөөврийн өсгөгч, 0.1 сая төгрөгийн 1 ш ус буцалгагчийг тус тус сургалтын танхимд байршуулан ашиглаж байна.

4. ХЭДС –аас Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр 36.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг олгосны ашиглалтыг үзэхэд “Урлан арвижих”, “Гэрэлт ирээдүй”, “Бат хэлхээ” бүлгүүдийн тоног төхөөрөмжийн ашиглалт хангалттай байна.
5. Харин Тэнхлэг бүлэг зарим тоног төхөөрөмжийг ашиглаагүй, “Хөгжил дэвшилд хамтдаа” бүлэг үйл ажиллагаа явуулаагүй байгаагаас үзэхэд төслийн хөрөнгийн ашиглалтын үр дүнг бууруулж байна.

Т.Ариун-Эрдэнэ ахлагчтай “Хөгжил дэвшилд хамтдаа” бүлгийн үйл ажиллагааг Улаанбаатар хотод газар дээр нь очиж шалгахад үйл ажиллагаа явуулаагүй байна.

Энэ нь 3.1 **“Төслийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа тогтоосон хугацаанд А талд үнэн зөв, бодитой тайлагнах үүрэгтэй”, 3.6 “төслийн үр дүнд байнгын ажлын шинэ байртай болж, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлсэн байна.”**, 3.4 **“гэрээ хүчин төгөлдөр болсноор төслийн хүрээнд эзэмших багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн захиалгыг үнэн зөв гаргаж өгнө. Төслийн хэрэгжилтэд олгосон багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу зарцуулна.”**, 6.6 **“ Б тал нь төсөл хэрэгжүүлэх хугацаанд гэрээгээ хүлээсэн үүргээ зөрчиж, хэрэгжүүлээгүй, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг зориулалтын бусаар зарцуулсан, тайлан мэдээгээ хуурамчаар гаргаж өгсөн нь тогтоогдвол хөтөлбөрийн 6.6-д заасны дагуу шийдвэрлэн, тоног төхөөрөмжийг нэг сарын хугацаанд буцаан төлнө.”** гэсэн заалтуудыг “Хөгжил дэвшилд хамтдаа” бүлэг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

ХЭДС-ийн хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн хөтөлбөрийн санхүүжилтийн бичиг баримтыг хянаж, зарим шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлүүлж хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад албан ёсны хяналт шалгалтыг Хөдөлмөрийн хэлтсээс хийгээгүй байна.

Энэ нь 6.2 “**гэрээний биелэлтийг гэрээнд оролцогч талууд улирал тутам дүгнэнэ.**”, 6.5 “**гэрээний хэрэгжилтэд А тал байнгын хяналт тавина.**”, 6.6 “**Б тал нь төсөл хэрэгжүүлэх хугацаанд гэрээгээг хүлээсэн үүргээ зөрчиж, хэрэгжүүлээгүй, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг зориулалтын бусаар зарцуулсан, тайлан мэдээгээ хуурамчаар гаргаж өгсөн нь тогтоогдвол хөтөлбөрийн 6.6-д заасны дагуу шийдвэрлэн, тоног төхөөрөмжийг нэг сарын хугацаанд буцаан төлнө.**” гэсэн заалтуудыг Хөдөлмөрийн хэлтэс бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавих үүрэгтэй боловч мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд 2015 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Аймгийн МСҮТ-ийн дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний ажилтан 2015 оны байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хяналт үнэлгээ хийж, тайлангаар байгууллагын үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ 80 хувьтай дүгнэгдсэн байна.

Уг тайланд мэргэжлийн боловсрол сургалтын талаар хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд ерөнхий үнэлгээ өгөгдөөгүй боловч Залуучууд, МБСБ-ын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг 90.3 хувь гэж үнэлжээ.

Аудитаар данс бүртгэлд тусгаагүй, төслийн хэрэгжилт хангалтгүй зэрэг нийт 25.4 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс холбогдох ТЕЗ, байгууллага, албан тушаалтанд зөрчлийг арилгах 8.4 сая төгрөгийн 1 хугацаатай албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлээ.

Тав. ДҮГНЭЛТ

1. Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хөрөнгө хуулийн дагуу олгогдсон боловч МСҮТ нь зарим хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй байна.

2. Мэргэжлийн боловсрол олгох чиглэлээр ХЭДС-аас бүлгүүдэд олгосон 36.3 сая төгрөгийн хөрөнгөөс 27.9 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлж байгаа ажиллаж байгаа боловч 8.4 сая төгрөгийн төслийн хэрэгжилт үр дүнгүй байгаа тул гэрээний дагуу хөрөнгийн ашиглалтад хяналт тавих шаардлагатай байна.
3. Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хандив, тусламж, төсөл хөтөлбөрөөр олгосон хөрөнгөд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Зургаа. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Хэнтий аймаг дахь МСҮТ-ийн захирал Л. Төмөрбаатар-т :

1. ДЗМОУБ-ын Хэнтий ОНХ хөтөлбөрөөс олгосон данс бүртгэлгүй байгаа 17.0 сая төгрөгийн 13 хүлэмжийг 2016 оны 3-р улиралд орлого авч, тайланд тусгах

Хөдөлмөрийн хэлтсийн дарга А.Жаргалсайхан-д:

2. Аудитаар өгөгдсөн албан шаардлагын хугацаанд гэрээний хэрэгжилт хангагдаагүй тохиолдолд тоног төхөөрөмжид зарцуулсан 8.4 сая төгрөгийг буцаан төлүүлэх арга хэмжээ авч ажиллах.
3. “Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжиж байгаа төслүүдийн гэрээний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар Аудитын газарт 2016 оны 10 дугаар сарын 01 гэхэд албан бичгээр танилцуулах.

Долоо. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Тайлангийн төслийг Хөдөлмөрийн хэлтсийн даргад 2016 оны 7 дугаар сарын 07-нд 148 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬГА
ХЭНТНИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

23118 Хэнтийн аймал, Харлан нгу, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: (078) 70-56-21-12
E-mail: khamti@aud.gov.mn

2016.07.07 № 4/5
ТАЙЛАН - ба № -т

АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА А.ЖАРГАЛСАЙХАН
ТАНАА

Аймгийн ИТХ-ын захиалга, аймгийн Аудитын газрын 2016 оны ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хандив, тусламж, төсөл хөтөлбөрийн зарцуулалт"-д хийж байгаа нийцлийн аудитын тайлангийн төслийг хүргүүлэв. Тайлангийн төсөлтэй танилцаад холбогдох саналаа албан бичгээр ирүүлнэ үү.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ЭНХТҮВШИН



Тайлангийн төсөлтэй танилцаад ирүүлсэн санал:



ХЭНТИЙ АЙМАГ
ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТЭС

23123 Өндөрхаан, Харлан сум
Утас/Факс: 70-56-22-26

2015.07.20 № 144
танай -ы № -т

Тайланд санал хүргүүлэх
тухай

ХЭНТИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

ЭН А. ТУС
Санал тайлан
тусгах

Б.Эр
Ун. 20

Мэргэжлийн сургалтыг дэмжих чиглэлээр олгосон хандив, тусламж төсөл хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалтанд аудит хийсэн тайлантай танилцаж үзлээ. Залуучууд мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 2015 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа оройтож Хөдөлмөрийн яам болон ХЭМСҮТ-н зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэн ажилласан. н.Ариун-эрдэнэ ахлагчтай Хөгжил дэвшилд хамтдаа бүлэг 8.4 сая төгрөгийн хэвлэлийн эх бэлтгэлийн тоног төхөөрөмж авч Чингис хотод үйл ажиллагаа эхлүүлсэн боловч зах зээл байхгүй гээд Улаанбаатар хотод үйл ажиллагаагаа явуулж байна. Аудитын шалгалтанд тоног төхөөрөмжөө хамруулаагүй байна. Цаашид хариуцсан мэргэжилтэн үйл ажиллагаанд нь байнга хяналт тавин ажиллах болно. Иймээс н.Ариун-Эрдэнэ ахлагчтай Хөгжил дэвшилд хамтдаа бүлэгийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа.

ДАРГА



А.ЖАРГАЛСАЙХАН

Хөтлөх хэрэг-1.6

D:/2015 on/Alban too/ too A4/ 000020

Тайлангийн төсөлтэй танилцаад ирүүлсэн Хөдөлмөрийн хэлтсийн албан бичигт ирүүлсэн саналын дагуу хэвлэлийн эх бэлтгэлийн чиглэлээр олгосон 8.4 сая төгрөгийн

төслийн хэрэгжилтийг Улаанбаатар хотод газар дээр нь очиж шалгахад үйл ажиллагаа явуулаагүй байгаа нь тогтоогдсон тул аудитын тайлангийн дүгнэлтэд өөрчлөлт оруулаагүй болно.

Тайлан бичсэн: Ахлах аудитор

Н.Туяа